



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2016 оны 08 сарын 10 өдөр

Дугаар А/101

Улаанбаатар хот

Шагнах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2.4.1 дэх заалт, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9 дэх заалт, Ерөнхий менежерийн шагналын журмын 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрчим хүчний ажилтны өдрийг тохиолдуулан цахилгаан эрчим хүчийг найдвартай дамжуулах үйлсэд идэвхи зүтгэл гарган эрчим хүчний салбарт үр бүтээлтэй ажиллаж байгаа Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Улаанбаатар салбарын дэд станцын засварын монтер Доржийн Батпүрэвийг Ерөнхий менежерийн “Өргөмжлөл”-өөр шагнасугай.

2. Өргөмжлөлийг дагалдах мөнгөн шагналыг өөрийн байгууллагын санхүүгээс гарган урамшуулахыг байгууллагын удирдлагад даалгасугай.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *[Signature]* С. ГАНТӨМӨР

УХА0501 9077367